



ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ  
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/81

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Монгол улсын Иргэний хуулийн 197 дугаар зүйлийн 197.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Эрдэнэс-Тавантолгой" хувьцаат компанийн дүрмийн 8.6.10, 9.5.2, 9.5.3, Хөдөлмөрийн дотоод журмын 2.5, 2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн эд хөрөнгийг олон нийтэд нээлттэй дуудлага худалдаагаар худалдахтай холбоотой "Дуудлага худалдаа зохион байгуулах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмын дагуу худалдан борлуулах эд хөрөнгийг тухай бүр компанийн Өмч хамгаалах байнгын зөвлөл болон Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан, шийдвэрлүүлж байхыг Нягтлан бодох бүртгэлийн хэлтэс /Г.Золжаргал/-т үүрэг болгосугай.

3. Журмыг батлагдсан өдрөөс мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Ерөнхий удирдлагын газар /Д.Энхболд/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ГАНХУЯГ

0100000681

Гүйцэтгэх захирлын 2020 оны  
03 дугаар сарын 14 ны өдрийн  
1/81 дугаар тушаалын хавсралт



## “ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ДУУДЛАГА ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь “Эрдэнэс-Тавантолгой” ХК /цаашид “Компани” гэх/-ийн эд хөрөнгийг олон нийтэд нээлттэй дуудлага худалдаагаар худалдах ажлыг зохион байгуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Компани эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан, эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгө /цаашид “эд хөрөнгө” гэх/-ийг компанийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр /тогтоол/-ийн дагуу дуудлага худалдаагаар худалдахад энэ журмыг баримтална.

1.3. Энэ журмаар зохицуулаагүй бусад харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Иргэний хууль, компанийн “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам” болон холбогдох бусад журам, зааврыг удирдлага болгон шийдвэрлэнэ.

### Хоёр. Зохион байгуулах комисс, түүний эрх, үүрэг

2.1. Энэ журмын 1.2-т заасан шийдвэрийн дагуу эд хөрөнгийн дуудлага худалдаа зохион байгуулах Байнгын комисс /цаашид “комисс” гэх/-ыг компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар томилно.

2.2. Комисс дараах бүрэлдэхүүнтэй байх бөгөөд компанийн тухайн чиглэл хариуцсан нэгжийн ажилтнуудаас бүрдэнэ. Үүнд:

2.2.1. Комиссын дарга

/ захиргаа, удирдлага хариуцсан нэгжийн удирдлага/

2.2.2. Дуудлага худалдаа эрхлэн хөтлөгч

/аж, ахуй хариуцсан нэгжийн удирдлага/

2.2.3. Нарийн бичгийн дарга буюу тэмдэглэл хөтлөгч

/үндсэн хөрөнгө хариуцсан ажилтан/

2.2.4. Гишүүд

/ хууль зүйн болон уул, уурхай хариуцсан нэгжийн ажилтан/

2.2. Комисс нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

2.2.1. худалдах эд хөрөнгө, түүний мэдээлэл, холбогдох материалтай танилцах;

2.2.2. дуудлага худалдааны зарыг нийтэд мэдээлэх;

2.2.3. дуудлага худалдаанд оролцохыг хүссэн этгээдийн хүсэлтийг хүлээн авах, бүртгэх;

2.2.4. дуудлага худалдааны явцад үүссэн аливаа асуудлыг комиссын хурлаар шийдвэрлэх;

2.2.5. худалдах эд хөрөнгийн материал, түүний чанар байдлыг харгалзан анхны дуудлага худалдаагаар худалдагдаагүй эд хөрөнгийн анхны үнийг 50 хүртэлх хувиар бууруулах;

2.2.6. дуудлага худалдаатай холбоотой гомдлыг ажлын 3 хоногийн дотор шийдвэрлэх;

### **Гурав. Дуудлага худалдааг зарлах**

3.1. Дуудлага худалдааны зарыг уг дуудлага худалдаа явуулахаар товлосон өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон компанийн цахим хуудсаар нийтэд мэдээлнэ.

3.2. Дуудлага худалдааны зард дараах мэдээллийг тусгана: Үүнд:

3.2.1. дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийн мэдээлэл, эрх бүхий этгээдийн шийдвэр;

3.2.2. дуудлага худалдааны анхны үнэ, ;

3.2.3. дэнчин болон хураамжийн хэмжээ, тушаах дансны дугаар;

3.2.4. дуудлага худалдаа зохион байгуулах газрын хаяг, холбоо барих утасны дугаар;

3.2.5. дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх хугацаа;

3.2.6. дуудлага худалдаа эхлэх, дуусах хугацаа;

3.2.7. эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний гол нөхцөл.

### **Дөрөв. Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх**

4.1. Дуудлага худалдаанд оролцох хүсэлтийг комисс дуудлага худалдаа явагдахаас 3 хоногийн өмнө урьдчилан цахим шуудангаар болон бичгээр авна.

4.2. Комисс дэнчин болон хураамжийг төлөөгүй тохиолдолд оролцогчийг бүртгэлээс хасна.

4.3. Дуудлага худалдаанд оролцогчийг энэхүү журмын хавсралтаар батлагдсан хүснэгтийн дагуу комиссын нарийн бичгийн дарга бүртгэнэ.

4.4. Дуудлага худалдаанд оролцохыг хүсэгч нь энэхүү журам болон ялагчтай байгуулах Худалдах, худалдан авах гэрээний нөхцөлийг зөвшөөрч, гарын үсэг зурж баталгаажуулна.

## **Тав. Дуудлага худалдаанд оролцогчийн эрх, үүрэг**

5.1. Дуудлага худалдаанд оролцох хүсэлтээ илэрхийлж, дэнчингээ зохих журмын дагуу байршуулсан, энэ журмын 4.1, 4.3-д заасны дагуу бүртгүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, дуудлага худалдаанд оролцох эрхтэй.

5.2. Дуудлага худалдаанд оролцогч дараах эрх эдэлнэ.

5.2.1. дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийн мэдээлэлтэй үнэ төлбөргүй танилцах;

5.2.2. дуудлага худалдаанд ялаагүй бол дэнчингээ буцаан авах;

5.2.3. дуудлага худалдааны журам зөрчигдсэн гэж үзвэл гомдлоо комисст гарган шийдвэрлүүлэх.

5.3. Дуудлага худалдаанд оролцогч дараах үүрэг хүлээнэ.

5.3.1. дуудлага худалдаанд оролцох хүсэлтээ хугацаанд нь ирүүлэх, хүсэлтэд дэнчин төлсөн баримт хавсаргах;

5.3.2. дуудлага худалдааны дэгийг сахих;

5.3.3. дуудлага худалдаанд ялсан тохиолдолд худалдан авсан хөрөнгийн үнийг энэ журмын 8.3-д заасан хугацаанд төлөх.

## **Зургаа. Дуудлага худалдааны анхны үнэ, дэнчин, дуудлага худалдааны өсгөн хэлэх үнийн хэмжээ**

6.1. Дуудлага худалдаагаар худалдах эд хөрөнгийн анхны үнэ нь компанийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр /тогтоол/-ээр тогтоосон үнэ байна.

6.2. Дуудлага худалдаанд оролцох дэнчингийн хэмжээ нь дуудлага худалдаагаар худалдах эд хөрөнгийн анхны үнийн дүнгийн 10 хувьтай тэнцүү байна.

6.3. Дэнчинг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн дансанд байршуулна.

6.4. Ялагчаас бусад оролцогчдын дэнчинг ямар нэг шимтгэлгүйгээр буцааж олгоно.

6.5. Дуудлага худалдаанд ялсан оролцогчийн худалдан авах хөрөнгийн үнийн төлбөрт дэнчинг оролцуулж тооцно.

6.6. Дуудлага худалдааны ялагч нь худалдан авсан хөрөнгийн үнийг энэ журмын 8.3-д заасан хугацаанд төлөөгүй бол тухайн хөрөнгийг худалдаж авах эрхээ алдах бөгөөд энэ тохиолдолд дэнчинг буцаан олгохгүй.

6.7. Дуудлага худалдаагаар өсгөн хэлэх үнийн хэмжээ нь тухайн эд хөрөнгийн үнэлгээнээс хамааран дор дурдсан хэмжээтэй байна. Үүнд:

6.7.1. эд хөрөнгийн анхны үнэ 1,000,000 хүртэл төгрөг бол өсгөн хэлэх үнийн хэмжээ 100,000 /Нэг зуун мянга/ төгрөг;

6.7.2. эд хөрөнгийн анхны үнэ 1, 000, 001-5,000,000 хүртэл төгрөг бол өсгөн хэлэх үнийн хэмжээ 200,000 /Хоёр зуун мянга/ төгрөг;

6.7.3. эд хөрөнгийн анхны үнэ 5,000,001-10,000,000 хүртэл төгрөг бол өсгөн хэлэх үнийн хэмжээ 300,000 /Гурван зуун мянга/ төгрөг;

6.7.4. эд хөрөнгийн анхны үнэ 10,000,001 төгрөгөөс дээш бол өсгөн хэлэх үнийн хэмжээ 500,000 /Таван зуун мянга/ төгрөг байна.

### **Долоо. Дуудлага худалдаа явуулах аргачлал, дараалал /дэг/**

7.1. Энэ журмын 5.1-д заасны дуудлага худалдаанд оролцохоор бүртгүүлсэн этгээд дуудлага худалдаанд оролцохоор ирэхдээ дэнчин тушаасан баримтаа дуудлага худалдааны тэмдэглэл хөтлөгчид хүлээлгэн өгнө. Дуудлага худалдааны тэмдэглэл хөтлөгч дуудлага худалдаанд оролцох хүсэлт, холбогдох материалын бүрдлийг шалгаж, оролцогчдын бүртгэлийг баталгаажуулна.

7.2. Дуудлага худалдаанд оролцох нэгээс илүү хүсэлт ирээгүй тохиолдолд комисс дуудлага худалдаа явуулах боломжгүй болсон талаар хүсэлт ирүүлсэн оролцогчид мэдэгдэх бөгөөд дахин дуудлага худалдаа явуулах талаар мэдээлнэ.

7.3. Дуудлага худалдаанд оролцогчид үнийн саналаа ээлж дараалан өсгөж хэлнэ. Дуудлага худалдааны ялагч нь хамгийн өндөр үнэ санал болгосон этгээд байна.

7.4. Дуудлагын худалдааны хөтлөгч нь дараах эрх, үүрэгтэй:

7.4.1. хөтлөгч худалдах эд хөрөнгийн үнэ, холбогдох бусад мэдээллийг товч танилцуулж, дуудлага худалдааны үнийг өсгөх хэмжээг энэ журмын 6.7-д заасны дагуу зарласнаар дуудлага худалдааг эхлүүлнэ.;

7.4.2. дуудлагын худалдаа эхэлснийг зарлан мэдээлсний дараа үнэ хаялцах ажиллагааг тусгай дохиогоор эхлэн дуудлагын худалдаанд оролцогчдын үнийн санал өгсөн дарааллаар дуудна;

7.4.3. дуудлагын худалдаанд оролцогчийн үнийн саналыг гурван удаа давтаж хэлнэ;

7.4.4. хамгийн сүүлд гарсан үнийн саналыг гурван удаа давтан "буулаа нэг, хоёр, гурав" гэж тоолсны дараа шинээр үнийн санал гараагүй бол тухайн эд хөрөнгийн дуудлага худалдааг дуусгавар болгон ялагчийг зарлан мэдээлнэ;

7.5. Дуудлага дуудлага худалдаанд 1-ээс илүү оролцогч бүртгүүлээгүй, энэ журмын 8.3, 8.4-д заасны дагуу гэрээ байгуулах эрх бүхий этгээд тодроогүй, эсхүл эрх бүхий этгээдийн шийдвэрээр дуудлага худалдааг дахин явуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд дахин дуудлага худалдаа зарлах бөгөөд энэ тохиолдолд худалдах доод үнийг энэ журмын 2.2.5-д заасны дагуу тогтоож болно.

7.6. Дуудлагын худалдааны тэмдэглэл хөтлөгч нь энэ журмын 7.1-д заасны дагуу оролцогчдыг бүртгэх, түүнчлэн дуудлагын худалдааны явцын тэмдэглэлийг үнэн зөв, бүрэн хөтлөх, дуудлагын худалдааны үнэ хаялцсан болон үнийн санал өгсөн дарааллаар явцын тэмдэглэлд тодорхой бичих үүрэгтэй.

### **Найм. Дуудлага худалдааны ялагчтай гэрээ байгуулах**

8.1. Дуудлага худалдааны ялагч нь хамгийн өндөр үнэ санал болгосон этгээд байна. Ялагч нь тухайн эд хөрөнгийг Худалдах, худалдан авах гэрээ байгуулах эрх бүхий этгээд болно.

8.2. Ялагч нь дуудлага худалдаа явагдсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор Иргэний хуулийн 197 дугаар зүйлд заасны дагуу компанитай гэрээ байгуулна. Гэрээнд дор дурдсан зүйлсийг зайлшгүй тусгана:

- 8.2.1. худалдан авсан эд хөрөнгийн нэр, тодорхойлолт, байршил;
- 8.2.2. эд хөрөнгийн гэрчилгээний дугаар, түүнд заагдсан бусад мэдээлэл;
- 8.2.3. дуудлага худалдаанд оролцохдоо тавьсан дэнчингийн хэмжээ;
- 8.2.4. худалдан авсан үнэ;
- 8.2.5. үнэ төлөх хэлбэр.

8.3. Дуудлага худалдааны ялагч компанитай гэрээ байгуулснаас хойш 7 хоногийн дотор төлбөрийг бүрэн хийнэ. Гэрээнд заасан үнийг бүрэн төлсөн нөхцөлд тухайн хөрөнгийг захиран зарцуулах эрхийг ялагчид шилжүүлнэ.

8.4. Ялагч нь энэхүү журмын 8.3-д заасан хугацаанд төлбөрийг шилжүүлээгүй тохиолдолд гэрээг цуцалж, дуудлага худалдааны шаардлага хангасан дараагийн оролцогчид эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ байгуулах эрхийг шилжүүлнэ.

### **Ес . Бусад зүйл**

9.1. Энэ журмыг зөрчсөн компанийн ажилтанд компанийн Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулна.

“Дуудлага худалдаа зохион байгуулах журам”-ын  
хавсралт

**ДУУДЛАГА ХУДАЛДААНД ОРОЛЦОГЧДЫН  
БҮРТГЭЛИЙН ХУУДАС**

<b>№</b>	<b>Дуудлага худалдаанд оролцогчийн нэр</b>	<b>Холбоо барих утас</b>	<b>Дуудлага худалдаагаар худалдах эд хөрөнгө</b>	<b>Дуудлага худалдаа явуулах журамтай танилцсан эсэх</b>	<b>Гэрээний нөхцөлийг зөвшөөрсөн эсэх</b>	<b>Гарын үсэг</b>

-----oOo-----